




“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Р.БУД

БАТЛАВ.



“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Р.БАТСҮХ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 2019/493
АТТ-19/242 д 13/28

Удаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын “Авто замын тухай хууль”, “Иргэний хууль”-ийн 343 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168, 2019 оны 45 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”, Зам, тээврийн хөгжлийн төвийн Захирлын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг үндэслэн зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын хүрээнд Зяхиялагч, Гүйцэтгэгчтэй холбогдон гаргах харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Нэг талаас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга О.Лхагвасүрэн (цаашид “Гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас магадлал хийлгэх хүсэлт гаргасан “Монголын төмөр зам” ТӨХК, түүнийг төлөөлж Инженер, технологийн хэлтсийн дарга Д.Нямлхагва (цаашид “Захиалагч” гэх) нар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.3. Баримт бичигт магадлал хийх ажлын талаарх мэдээлэл:

- | | |
|------------------------------|---|
| Захиалагч: | “Монголын төмөр зам” ТӨХК |
| Хөрөнгө оруулалт: | “Монголын төмөр зам” ТӨХК |
| Ажлын даалгавар гүйцэтгэсэн: | “Монголын төмөр зам” ТӨХК |
| Объектын нэр: | Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл. |
| Магадлал хийх ажлын нэр: | Нэг километр технологийн зориулалт бүхий түр зам барих ажлын төсөвт өртөгийн тооцоо |

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх үйл ажиллагааг 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргаснаар гэрээ дуусгавар болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөр

3.1 Нийт магадлалын ажлын хөлс, төлбөр нь Зам, тээврийн хөгжлийн төвийн Захирлын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Зам, замын

байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын 6.3-д заасан үнэ буюу 200 000 ₮ (хоёр зуун мянган төгрөг)

3.2 Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийлгэх ажлын хөлсийг Захиалагч нь Гүйцэтгэгчийн **Хаан банк 5013170959** тоот дансанд гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлсэн байна.

3.3 Ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамааран томоохон хэмжээний ажлын хувьд урьдчилгаа гэрээний үнийн дүнгийн 30%-ийг төлж гэрээ байгуулна.

3.4 Магадлалын ерөнхий дүгнэлт гарч Захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш үлдэгдэл төлбөр 70%-ийг төлнө.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

Гүйцэтгэгч дараах эрх, үүрэгтэй:

2.1. “Зам, тээврийн хөгжлийн төв”-ТӨҮГ-ын Захирлын 2017 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 8 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн баримт бичгийн бүрдлийг хянах маяг”-ын загварын дагуу Захиалагчаас тухайн ажилд шаардагдах материал, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг гаргуулж авах;

2.2. Зураг төслийн баримт бичгийн бүрдлийн шаардлага хангаагүй тохиолдолд Захиалагчид нэн даруй мэдэгдэх;

2.3. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168, 2019 оны 45 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ын 9 дүгээр зүйлийг үндэслэн магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах.

2.4 Зураг төсөлд хэсэгчлэн магадлал хийж болно.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

Захиалагч дараах эрх, үүрэгтэй:

3.1. Захиалагч орон тооны бус Экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дахин Эксперт томилуулах санал оруулах;

3.2. Томилогдсон орон тооны бус Эксперт магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд Захиалагчид энэ талаар ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж, экспертийг дахин томилуулах;

3.3. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

3.4. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

3.5. Магадлалын дүгнэлтийн дагуу зам, замын байгууламжийн зураг төслийг хянан нягталж, Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан холбогдох залруулгыг хийж, тодруулга тайлбарыг гаргасан байх;

3.6. Энэхүү гэрээний 1.4-д заасан хугацаатай уялдуулан орон тооны бус Экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга (засвар)-ыг ажлын 6 хоногт багтаан хийж дуусган, Экспертээр хянуулж, баталгаажуулан, Гүйцэтгэгчид хүргүүлсэн байх.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээ сунгах бол тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэж, сунгах эсэх асуудлыг талууд тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

4.2. Зураг төслийн магадлалын ажлыг гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 3.6-д заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

4.3. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон нөхцөлд зайлшгүй нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

4.4 Гэрээний талуудын Санхүү хариуцсан нэгж төлбөр, тооцооны асуудлаар тухай бүр тооцоо нийлсэн байна.

Тав.Маргааныг шийдвэрлэх

5.1. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн маргааныг аль болох зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.2 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

Энэхүү гэрээг талууд 3 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Зам, тээврийн хөгжлийн төвийн Зураг төслийн магадлал, стандарт нормативын хэлтсийн дарга

 О.ЛХАГВАСҮРЭН

Зам, тээврийн хөгжлийн төвийн нягтлан бодогч

 З.ЗОЛЖАРГАЛ

Хуулийн асуудал, гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

 Ч.САРУУЛ

Зураг төслийн магадлал хариуцсан мэргэжилтэн

 С.МӨНХТУЯА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын төв байр,


Утас:70001150

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


"Монголын төмөр зам" ТӨХК, түүнийг төлөөлж Инженер, технологийн хэлтсийн дарга

 Д.НЯМЛХАГВА

Материалын инженер, төсөвчин

 С.ОДОНТУНГАЛАГ

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

 Д.БАЯРХҮҮ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол /14230/, Нарны зам-62 Юнион бюлдинг А блок 7 давхар

Утас: 70006622